

Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга,
нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 10 дугаар хавсралт


Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр: **Аймгийн Засаг дарга**

(Хуулийн 6.4.8, 6.8.1 заалтын хүрээнд)

Д/д	Шийдвэр гаргагч	Шийдвэрийн огноо	Шийдвэрийн дугаар	Төрөл/хөрөнгө зарцуулах, өр авлага үүсгэх	Шийдвэрийн хуулбар
1	Аймгийн Засаг дарга	2022.10.06	Б/62	Дэмжлэг үзүүлэх тухай	
2	Аймгийн Засаг дарга	2022.10.19	Б/64	Дэмжлэг үзүүлэх тухай	

Төрийн сангийн мэргэжилтэн: **Б.Гантулга**



Холбогдох утас: 70384096, 88089938
И-мэйл хаяг: b.gantulga@khs.gov.mn



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 5/64

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар тогтоол, Засаг даргын зөвлөлийн хурлын 26 ,27 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зүүн хөлөндөө протез хийлгэхэд санхүүгийн дэмжлэг хүссэн Ренчинлхүмбэ сумын харьяат иргэн М.Борхүүд 3,000,000 (Гурван сая) төгрөг, Бөөрний хавдар үсэрхийлсэн оноштой эмчилгээний зардал хүссэн Мөрөн сумын харьяат Г.Батбаярт 1,000,000 (Нэг сая) төгрөг, гэр нь галд өртөж, 2 хүүхэд нь нас барсан иргэн Г.Мөнхтуяад 2 сая (Хоёр сая) төгрөгний, “Сод-Эрдэм” сургуулийн захирал Д.Мөнхбааатар бөөр шилжүүлэн суулгах хагалгаанд ороход 2,000,000 (Хоёр сая) төгрөгний дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх дэмжлэгийн зардалд нийт 8,000,000 (Найман сая) төгрөгийг аймгийн Засаг даргын ерөнхий дансны Иргэд байгууллагын асуудал шийдвэрлэх зардлаас гаргаж зарцуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Х0106 - 83115 - 2109011



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 06 өдөр

Дугаар Б/62

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит IX хуралдааны 05 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 26 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Өсвөр үе, хүүхэд, залуучуудын нийгмийн харилцаанд оролцох боломжийг нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх, хөгжилд суурилсан хамгааллын үйлчилгээг түгээн дэлгэрүүлэх, орон нутгийн хүүхэд, залууст тэгш боломж хүртээмжийг бий болгох зорилгоор баригдаж буй “Ид шидийн орон” жишиг төвийн үйл ажиллагааг дэмжих зардалд 10,000,000 (арван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг Засаг дарга дансны “Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээний зардал”-аас гаргаж зарцуулахыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий санхүүчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. “Ид шидийн орон” жишиг төвд зарцуулах дэмжлэгт хяналт тавих, мэдээллээр хангаж ажиллахыг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга (Ч.Дашбаяр), үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Цэцэгмаа) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН